



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Барилгын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 02/2014 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ажлын байрны зааварчилгаа өгөх аргачилсан зөвлөмж" /БД 12-108-14/ барилгын дүрмийг хавсралт ёсоор баталж, 2014 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Шинээр батлагдсан барилгын дүрмийг хэвлэн олшруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх, сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Барилгын хөгжлийн төв /Б.Баярсайхан/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Цэдэнсамба/-г даалгасугай.



Ц.БАЯРСАЙХАН

08 000333

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН ДҮРЭМ

**АЖЛЫН БАЙРНЫ ЗААВАРЧИЛГАА
ӨГӨХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ**

БД 12-106-14

Албан ёсны хэвлэл

**МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

УЛААНБААТАР ХОТ
2014 ОН

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН ДҮРЭМ

**АЖЛЫН БАЙРНЫ ЗААВАРЧИЛГАА
ӨГӨХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ**

БД 12-106-14

Албан ёсны хэвлэл

**МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

УЛААНБААТАР ХОТ
2014 ОН

1. Барилга, хот байгуулалтын сайдын 20... оны ... дугаар сарын ... – ны өдрийн ... дүгээр тушаалын ... хавсралтаар батлав.

Боловсруулсан:	Д.Даадшин	Монгол Улсын зөвлөх инженер
	Г.Батнэмэх	Монгол Улсын зөвлөх инженер
	Д.Нямдэлгэр	Мэргэшсэн инженер

Хянан тохиолдуулсан:	Г.Батнэмэх	Монгол Улсын зөвлөх инженер
----------------------	------------	-----------------------------

Энэхүү барилгын дүрмийг Барилгын хөгжлийн төвийн зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

АЖЛЫН БАЙРНЫ ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ

SAFETY INSTRUCTIONS FOR JOB DESCRIPTIONS

АЖЛЫН БАЙРНЫ ЗААВАРЧИЛГАА ӨГӨХ АРГАЧИЛСАН ЗӨВЛӨМЖ

БД 12-106-14

1. Зорилго

1.1 Барилгын үйлдвэрлэлийн явцад гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчлагыг оновчтой хэлбэрээр, богино хугацаанд өгч, хүн бүрд эзэмшүүлэх.

1.2 Эрсдэлээс хамгаалах ажилд компьютер болон сүүлийн үеийн мэдээллийн технологийг ашиглах боломжийг бүрдүүлж, барилгын талбайн инженерийн ажилтай уялдуулж нийцүүлэх.

2. Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1. Барилга угсралтын аж ахуйн нэгжүүд нийгмийн хамгааллын ажлыг энэхүү дүрмийн А бүлгийг үндэслэн боловсруулж, зохион байгуулалтын арга хэмжээг урьдчилан төлөвлөж хэрэгжүүлнэ.

2.2. Барилга угсралтын аж ахуйн нэгж болон талбайн инженер техникийн ажилтан нар эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг В, С бүлгийн дагуу тус бүрд нь кодоор эрэмбэлж, хэрэгжүүлнэ.

3. Норматив ишлэл

3.1 Энэхүү дүрмийг боловсруулахад дараах хууль, стандарт, норм дүрмийг иш татаж хэрэглэсэн болно. Хэрэв эдгээр баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

-MNS OHSAS-18001:2012 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо шаардлага

-MNS6228-1:2010 Барилгын ажилчдын мэргэжлийн стандарт. 1-р хэсэг: ерөнхий шаардлага

-MNS6228-2:2011 Барилгын материалын үйлдвэрийн ажилчдын мэргэжлийн стандарт. 2-р хэсэг: ерөнхий шаардлага

-MNS6228-3 :2011 Барилгын механизмын ажилчдын мэргэжлийн стандарт. 3-р хэсэг: ерөнхий шаардлага

БД 12-105-07 Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм,

БД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн заавар,

БНБД 12.03.04 Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм,

БНБД 12.04.06 Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм,

Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгаа

БД 12-102-04 Барилгын инженер-геологи, геотехникийн ажилд мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм. Үндсэн шаардлага

4. Нэр томьёо, тодорхойлолт

4.1 Загвар–гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх ажлын эрэмбэлэлтийг;

4.2. Бүлэглэх- Гарч болзошгүй осол түүнээс сэргийлэх ажлыг төрөлжүүлэхийг;

А-Барилгын талбайд ажиллагсдын нийгмийн хамгааллын ажлын бүлгийг;

В-Барилгын үйлдвэрлэлийг машин механизмаар гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй ослын эрсдэлийн бүлгийг;

С- Барилгын үйлдвэрлэлийн бүх төрлийн ажлыг хүний биеийн хүч, мэргэжлийн ур чадвараар гүйцэтгэх явцад үүсэж болзошгүй ослын эрсдэлийн бүлгийг;

4.3. Кодлох- Барилгын ажилд гарч болзошгүй ослыг бүлэг тус бүрт задалж тодорхойлохыг;

5.Ерөнхий зүйл

5.1. Барилгын үйлдвэрлэлд гарч болзошгүй ослыг гурван бүлэг болгон ангилна. Үүнд:

- А бүлэг. Барилгын үйлдвэрлэл дээр ажиллагсдын нийгмийн хамгаалалтай холбоотой бүх ажил хамаарна. Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудад тус тус заасны дагуу ажилтны хөдөлмөрийн аятай нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох зэрэг асуудлыг шийдвэрлэх, ажил үргэлжлэх хугацаа, ачаалал болон ажилчны сэтгэцийн, оюуны, биеийн эрүүл мэндийг хамгаалах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, мөн түүнчлэн харилцааны соёл, хувь хүний төлөвшилт, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авч ажиллах, сэтгэл санаа урам зоригийн дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хэрхэн гүйцэтгэхийг А бүлэгт кодлон мөрдөнө. Тухайн асуудлыг ажил олгогч, ажилтан нар харилцан ойлголцож хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээнд тусган холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж ажиллана. Энэхүү асуудалтай холбогдон гарах эрсдлийн болон бусад асуудлыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хариуцан гүйцэтгэнэ.

- В бүлэг. Барилгад төрөл бүрийн хүнд хөнгөн механизм, тоног төхөөрөмж, механикжсан болон цахилгаан багаж хэрэгслэл, хийн ба цахилгаан гагнуур зэргийг ашиглан гүйцэтгэх үеийн бүх ажил.
- С бүлэг. Барилгын үйлдвэрлэлийн бүх төрлийн ажлыг хүний биеийн хүч, мэргэжлийн ур чадвараар гүйцэтгэх үеийн ажлууд тус тус хамаарна.

5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлыг бүлэглэж кодлох аргачлал

5.2.1 Барилгын аж ахуйн нэгжүүд MNS OHSAS 18001:2012, MNS 4969:2000 стандарт, хөдөлмөрийн тухай хуулийн 2-р бүлгийг удирдлага болгож болгож ажиллана.

5.2.2 Барилгын аж ахуйн нэгж байгууллага болон талбайн инженерүүд, ХАБЭА-н ажилтнууд В,С бүлэг тус бүр дээр хавсралт жишээний загвараар хариуцан барьж байгаа барилгын ажлын явцад хийгдэх ажлыг кодлон тодорхойлох ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

5.2.3 Барилгын ажлын технологитой шууд холбоотой эрсдэл, технологитой холбоогүй хүний буруу үйл ажиллагаанаас шалтгаалж гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан ангилж сэргийлнэ.

5.2.4 Болзошгүй ослоос сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй болгохын тулд аюул ослоос сэргийлэх, хамгаалах зааварчилгааг маш богино хугацаанд оновчтой хэлбэрээр чанга яригчийн тусламжтайгаар ажилчдад хүртээмжтэй хүргэх, ажилчдыг итгэл үнэмшилтэй байлгах зэрэг ажлуудыг байнга хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих, илэрсэн алдаа, зөрчил дутагдлыг тухай бүрт нь засаж залруулна. Ийм аргаар ажилчид, хамт олныг аюул ослоос сэргийлэх арга барилд дадлагажуулж, идэвхижүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна.

6. В, С бүлгийн ажлыг кодолж, тодорхойлсон жишээ.

6.1 Болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх ажлыг кодолж тодорхойлохдоо код бүр дээр ХАБЭА-н стандарт, норм дүрмийн заалт, хэм хэмжээг заавал зааж байна.

6.2 Ажил гүйцэтгэх төслийн дагуу ажлын явцад гарч болох ослын эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг заасан байна.

В. Барилгын хүнд, хөнгөн механизм, тоног төхөөрөмж, механикжсан багаж хэрэгсэл, цахилгаан, шатдаг хий ашиглах, хийн болон цахилгаан гагнуурын ажил зэрэг техникийн үйл ажиллагааны үед гарч болзошгүй ослоос сэргийлэх ажлуудын жишээ.

1-р хавсралт

код	Гүйцэтгэх ажил	Гарч болох эрсдэлээс сэргийлж, авах арга хэмжээ
В _{бу1}	Бульдозероор ажил	<u>Байгууллагын үүрэг</u> 1. Ажил гүйцэтгүүлэхийн өмнө уг газар доогуур

	гүйцэтгэх.	<p>инженерийн шугам, сүлжээ байгаа эсэхийг урьдчилан шалгаж, шороонд дарагдахаас сэргийлэх хамгаалалт хийж, хязгаарлах шугамыг тогтоон аюулгүй ажиллагааг хангасан байна.</p> <p>2. Бульдозерын операторчны мэргэжлийн үнэмлэхийг шалгаж, техникийн бэлэн байдлыг тодруулсан байна.</p> <p>3. Бульдозероор ажил гүйцэтгэх болон ухрах сул явалтын үед эд материал, ажиллагсдыг дайрагдахгүй байх арга хэмжээ авсан байна.</p> <p>4. Шороог түрэх ажлыг зааварчлах хүнийг томилж, ажиллуулахдаа бульдозерт дайрагдахаас сэргийлэх зааварчилгааг ажилчин болон операторт өгнө.</p> <p>5. Суурийн хажуугаар шороо буцааж хийхэд суурийн хажуу хэсэгт хүн ажиллах, багаж хэрэгсэл материал байлгахыг хориглоно.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.</p> <p>2. Бульдозероор ажил гүйцэтгэх болон ухрах сул явалтын үед эд материал болон өөрөө дайрагдахгүй байхад анхаарлаа хандуулж, ажиллана.</p> <p>п. ...</p>
В _{эк1}	Экскаватораар ажил гүйцэтгэх.	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Экскаватораар газар ухахын өмнө уг газар доогуур инженерийн шугам, сүлжээ байгаа эсэхийг урьдчилан шалгаж, хамгаалалт хийж, хязгаарлах шугамыг тогтоон аюулгүй ажиллагааг хангасан байна.</p> <p>2. Экскаваторын операторчны мэргэжлийн үнэмлэхийг шалгаж, техникийн бэлэн байдлыг операторчноос асууж тогтоосон байна.</p> <p>3. Экскаватороор газар шорооны ажил гүйцэтгэх талбайд хязгаарлалтын бүс тогтоож тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалт, туузаар тоногловсон байна.</p> <p>4. Ухах газрын талбайн болон гүний хэмжээг тооцоолж экскаваторын операторчинтой хийх ажлын технологи, дохиоллыг тохиролцсон байна.</p> <p>5. Экскаваторын шилжих хөдөлгөөн хийх чиглэл, орон зайн хэмжээг тогтоож аюулгүй ажиллагааг хангасан байна.</p> <p>6. Ухсан шороог овоолох, машинд ачих ажлын технологийг операторчин болон бусад ажилчдад зааж аюулгүй ажиллагааг хангасан байна.</p> <p>7. Экскаваторчинтой хамт ажиллаж байгаа ажилчид болон жолооч нарт аюулгүй ажиллах арга барилыг зааж өгсөн байна.</p> <p>8. Экскаваторыг галын аюулд өртөх эвдрэл гэмтэл авахаас хамгаалах зааварчилга өгсөн байна.</p> <p>9. Экскаваторыг ажил дууссаны дараа ажлын</p>

		<p>талбараас гаргаж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, талбай зогсоолд тавьсан байна.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ. 2. Экскаваторын шанаганы хүрч, үйлчлэх бүсэд орохыг хориглоно. <p>п. ...</p>
В_{к1}	Кранаар ажил гүйцэтгэх.	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Краны сумны үйлчлэх хүрээг талбайн зохион байгуулалтын зургийн дагуу тогтоож, тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалт, туузаар хязгаарлаж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2. Мэргэжлийн байгууллагын техникийн магадлалыг үндэслэж, хяналтын байгууллагын байцаагчаас зөвшөөрөл авсан краныг ашиглана. 3. Ажил эхлэхийн өмнө шаардлагатай бол кранчны үнэмлэхийг шалгаж, краны бүрэн бүтэн байдлыг кранчин болон краны бүрэн бүтэн байдлыг хариуцагчаас нь баталгаа гаргуулж, найдвартай ажиллагааг хангуулна. 4. Ажлын явцад техникийн гэмтэл, согог гарвал краны бүрэн бүтэн байдлыг хариуцагчид хандан баталгаа гаргуулна. 5. Краны паспортад заагдсан даац болон өнгийлтийн хамаарлын графикийг ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч мөрдөн оосорлогч, дохиочны ажилд хяналт тавьж ажиллана. 6. Кранчин болон хамт ажиллагсдад кранаар ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны санамж, зөвөлгөө өгсөн байна. 7. Кранаар ачаа шилжүүлэх үеийн аюулгүй ажиллагаа хариуцагч нь ачаа өргөх тэнжээ, оосорлох хэрэгслийн чанарыг урьдчилан шалгаж, өргөх ачаандаа тохируулан сонголт хийсэн байна. 8. Тэнжээ, оосорлох хэрэгслийн ачаа өргөх даацын хэмжээг тодорхойлсон техникийн паспортыг байнга шалгана. 9. Тэнжээ, оосорлох хэрэгсэлд тогтмол үзлэг хийж, техникийн шаардлага хангахгүй бол устгал хийнэ. 10. Үзэгдэх орчин далдлагдсан болон ачааг дамжуулах, өргөж шилжүүлэх үед оосорлогч, дохиочин байхгүй бол ажиллуулахыг хориглоно. 11. Краны паспортад заагдсан салхины зөвшөөрөгдөх хурд хэтэрсэн үед краныг ажиллуулахыг хориглоно. 12. Дуу цахилгаантай бороотой үед краныг ажиллуулахыг хориглоно. 13. Краны үйлчлэх хүрээнд өндөр хүчдэлийн шугам

		<p>байгаа эсэхийг шалгаж, аюулгүй ажиллах арга хэмжээг авсан байна.</p> <p>14. Краныг заавал оосорлогч, дохиочинтой ажиллуулна.</p> <p>15. Краны үйлчлэх хүрээнд гэрэлтүүлгээр хангасан байна.</p> <p>16. Өргөх ачааны урт, хүндийн хэмжээг заасан пайзтай байна.</p> <p>17. Тухайн өдөрт хийх ажилтай уялдуулж кранчин, хамт ажиллагсдад тодорхой зааварчилга өгсөн байна.</p> <p>18. Краны үйлчлэх хүрээний аюултай хэсгийн дор ажилчид явах чиглэл замыг хааж аюулгүй явах замыг тогтоож өгсөн байна.</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ. 2. Краны ачааны үйлчлэлийн хүрээнд зогсохыг хориглоно.
В _{ш1}	Бетон шахуургаар ажил гүйцэтгэх	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Бетон зуурмагийн шахуургын тулгуураас ирэх даралтын хүчийг эзэмшигч байгууллагаас нь тодруулж, тулгуур тулах газрын дор байрлах суваг шуудуу, инженерийн шугам, сүлжээ, сул хөрс байгаа бол тэдгээр нь цөмрөх эрсдэлийг шалган, тодорхойлж, шахуургын эргэн тойронд тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалт, туузаар хязгаарлаж, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2. Зуурмагийн шахуургын зогсох хөрсний гулгалт үүсэхээргүй талбайг шалгаж тэгшилж бэлдсэн байна. 3. Бетон шахуургын тулгуурыг паспортад заасан хэмжээнд сунган байрлуулна. 4. Шахуургын хошуу савж, осол гарахаас сэргийлсэн байх 5. Бетон цутгах үеийн аюулгүй байдлыг хангах иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх. 6. Бетон шахахын өмнө хэв хашмалын тулгуурын тогтворжилтын найдвартай байдлыг байнга шалгаж, найдвартай болгох 7. Бетоныг цутгах үеийн цаг агаарын байдал, ажиллах нөхцөл, ажлын цагийн үргэлжлэх хугацаа зэргийг урьдчилан тооцож аюулгүй ажиллагааг хангах 8. Бетон зуурмаг хүний бие рүү шүршигдэхээс урьдчилан хамгаалах зэрэг зүйлээс урьдчилсан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахыг хариуцсан инженер техникийн ажилтанд даалгах <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ. 2. Шахуургын хоолойд хуримтлагдсан хийг бүрэн гараагүй үед уян хоолойд цохиулахаас сэргийлэх

В_{ц1}	Өндөр хүчдэлийн шугамын ойр ажиллах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Цахилгааны өндөр хүчдэлийн шугамын байршлыг тодорхойлж, хязгаарлалтын бүс тогтоож тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалт болон тууз ашиглан гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.</p> <p>2. Цахилгаанаас хамгаалах анхааруулга санамжийг байрлуулсан байна.</p> <p>3. Цахилгаанд цохиулах эрсдэлээс хамгаалах багаж, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан байна.</p> <p align="center"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.</p> <p>2. Зөвшөөрөлгүй хамгаалалтын бүсэд орохыг хориглоно.</p>
В_{ц2}	Цахилгааны эх үүсвэр ашиглах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Барилгын ажил гүйцэтгэхэд шаардагатай зориулалтын цахилгаан залгууруудыг урьдчилан тодорхойлж цэг бүр дээр мэргэжлийн цахилгаанчнаар холбуулж, багаж хэрэгслийг ажиллуулна.</p> <p>2. Цахилгаан байгууламжийн тоног төхөөрөмжтэй ажиллахдаа цоожлох, пайзлах системийг хэрэгжүүлсэн байна.</p> <p>3. Цахилгааны самбар нь газардуулгыг шалгасан акттай байна.</p> <p>4. Цахилгааны самбарт уртасгагчийг мэргэжлийн бус ажилчид залгахыг хатуу хориглоно.</p> <p>5. Цахилгааны самбар, уртасгагч залгуур зэргийг ус чийгэнд өртөгдөхөөргүйгээр хамгаалагдсан байна.</p> <p>6. Цахилгааны шугам уртасгагч залгуурыг цохигдож гэмтэхээс сэргийлсэн байна.</p> <p>7. Цахилгаанаар ажилладаг тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ажиллуулах талаар ажилчдад цахилгааны онол, практикийн сургалт явуулж, тодорхой зааварчилгаа өгсөн байна.</p> <p>8. Ажил тарахад цахилгааны залгууруудыг цахилгааны самбараас салгаж хадгалсан байна.</p> <p>9. Өндөр хүчдэлийн агаарын шугамын аюулгүй зай хэмжээг ажилчдад зааж зааварласан байна.</p> <p align="center"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.</p> <p>2. Гэмтэл гарсан үед зөвхөн мэргэжлийн цахилгаанчинд хандана.</p>
В_{цхг1}	Цахилгаан болон хийн гагнуурын ажил	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Цахилгаан болон хийн гагнуур хийхийн өмнө аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангасан байна.</p> <p>2. Хүчилтөрөгчийн болон шатдаг хийн даралттай савыг аюулгүй ашиглах зааврыг урьдчилан өгсөн байна.</p>

		<p>3. Гагнуур хийх үед гал гарах нөхцөлөөс бүрэн сэргийлсэн байна.</p> <p>4. Гагнуурчин болон туслах ажилчинд аюулгүй ажиллах дэлгэрэнгүй зааварчилга өгсөн байна.</p> <p>5. Ажлын хувцас болон хамгаалах хэрэгслийн чанар бүрэн бүтэн байдлыг шалгаж аюулгүй ажиллагааг хангасан байна.</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ. 2. Бороо орсон үед болон чийгтэй нөхцөлд гагнуур хийхийг хориглоно.
В_{бм1} (баг а механикж уулалт)	Талбайн болон гүний доргиураар төрөл бүрийн бүтээцийн бетоныг нягтруулах, тэгшлэх ажил	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Каркасан бүтээцийн бетоныг норм зөрчиж, нягтруулснаас болж, хэв задрахаас хамгаалах 2. Хэв хашмалын тулгуур, холбоосыг бетон чигжих үед шилжилт гарах болон задрахаас сэргийлэх 3. Доргиураар осолгүй ажиллах арга барилыг ажилчдад эзэмшүүлсэн байна. <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ. 2. Багаж хэрэгслийг ашиглалтын зааврын дагуу ашиглана. 3. Төрөл бүрийн доргиурыг салгалгүйгээр зөөвөрлөх үед доргиурт цохиулах, доргиурын хүчинд савж унахаас сэргийлнэ.
В_{бм2}	Бага механикжуулалтын хэрэгслээр гүйцэтгэх ажил	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хэрэглэх багаж, тоноглолыг ашиглах талаар сургалт зохион байгуулж, гэрчилгээ олгуулах ажлыг зохион байгуулсан байна. 2. Хамт ажиллаж байгаа ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчлагыг тогтмол өгнө. <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ. 2. Бага механикжуулалтын хэрэгслээр осолгүй ажиллах арга барилыг ажилчдад эзэмшүүлсэн байна.
.....		
В_n		

ТАЙЛБАР:

В бүлгийн эрсдлээс сэргийлэх ажлийг гүйцэтгэхдээ дараах норматив баримт бичгийг мөрдөнө.

1. Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх дүрэм 2010
2. Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм 2010

3. Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм 2011
4. Зорчигчийн ган татлагат дүүжин болон чирэх замыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм 2010
5. Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм 2008
6. Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм 2008
7. Манипуляторыг краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм

С. Барилга угсралт ажлыг хүний биеийн хүч, мэргэжлийн ур чадвараар гүйцэтгэх үед гарч болзошгүй ослоос сэргийлэх ажлуудын жишээ

2-р хавсралт

код	Гүйцэтгэх ажил	Аюулгүй ажиллагааны арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх арга хэмжээ
С₁	Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг хэрэглэх	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Ажилчдыг иж бүрэн ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангасан байна. 2. Хамгаалах хэрэгсэлгүйгээр ажил гүйцэтгүүлэхийг хориглоно. 3. Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хэрэгжилтийг тогтмол зохион байгуулна. <p>п. ...</p> <p align="center"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэл, ажлын хувцасыг бүрэн хэрэглэнэ. 2. Хэрэглэж буй хувцас, хэрэглэлийн бүрэн бүтэн байдалд хяналт тавина. 3. Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэлийг зааврын дагуу хэрэглэж, өөр зүйлд ашиглахыг хориглоно. <p>п. ...</p>
С₂	Барилгын талбайн эмх цэгцтэй байдлыг хангуулах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын ажлын талбайг ажил гүйцэтгэх төсөлд заасны дагуу зохион байгуулж, эмх цэгцтэй байдлыг хангуулна. 2. Баригдаж буй барилгын дээрээс юм унах, суурийн хажуу эргээр нуралт үүсэх зэрэг аюулаас сэргийлэх арга хэмжээг урьдчилан авсан байна. 3. Ажилчдад барилгын талбайн эмх цэгцтэй байдлыг хангуулах талаарх зааварчилгааг өгсөн байна. 4. Барилгын хог хаягдлыг тухай бүр нь зайлуулсан байна. <p>п. ...</p> <p align="center"><u>Ажилчны үүрэг</u></p>

		<ol style="list-style-type: none"> 1. Барилгын дотор гадна талд дээрээс аливаа зүйлийг хаях, хог буулгах, буруу үйлдлийг бүрмөсөн хориглоно. 2. Барилгын талбайн эмх цэгцтэй байдлыг хангуулах талаарх зааварчилгааг баримталж ажиллана. п. ...
С₃	Арматур, хэв хашмалын ажил гүйцэтгэх	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Арматур, хэв хашмалын ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилчдад тогтмол өгнө. 2. Арматур, хэв хашмалын ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны арга хэмжээг урьдчилан зохион байгуулна. п. ... <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Арматур, хэв хашмалын ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Ажил гүйцэтгэх үед хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. п. ...
С₄	Барилгын төрөл бүрийн хэв хашмалыг буулгах, задлах, хураах, тулгуурыг суллаж авах ажил гүйцэтгэх	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын төрөл бүрийн төмөр бетон бүтээцийн хэв хашмалын тулгуур төмөр, модыг технологийн дагуу аюулгүй авах зааварчилгааг өгнө. 2. Ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилчдад тогтмол өгнө. 3. Аюулгүй ажиллагааны арга хэмжээг урьдчилан зохион байгуулна. п. ... <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Ажил гүйцэтгэх үед хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. п. ...
С₅	Шатны хонгилын хашлага хана, давхар хоорондын өндрийн ялгааг тооцож хэвтээ, босоо	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Шатны хонгилын хашлага ханыг тухайн давхарт нь заавал өрж битүүлсэн байна. 2. Хэвтээ босоо чиглэлд хамгаалалтыг найдвартай хийж, хяналт тавина. 3. Шатны түр хашлагыг хийж, найдвартай ажиллагааг хангуулна. 4. Тагтны хайс, тоноглол хийх үед түр хамгаалалтыг тогтмол хийнэ.

	чиглэлд аюулгүй байдлын хамгаалалтыг найдвартай хийж гүйцэтгэх	<p>п. ...</p> <p><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Цахилгаан шатны хонгилын нүх, шатны хажуу уруу унахаас сэргийлж ажиллана. 2. Ажил гүйцэтгэх аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 3. Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. <p>п. ...</p>
С ₆	Барилгын гадна дотор заслын ажил гүйцэтгэх	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын заслын ажлыг гүйцэтгэхэд хэрэглэх багаж хэрэгсэл, аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгслээр хангана. 2. Угсармал шат, хамгаалалтын шат, өргөх төхөөрөмжийг савалтаас сэргийлж, хананд найдвартай бэхэлнэ. 3. Ажлын шат, вандангийн найдвартай байдлыг байнга шалгана. 4. Заслын ажилчдыг мэргэжлийн багаар бүрдүүлж, зөв зохион байгуулна. 5. Гадна талын заслын ажлыг гүйцэтгэх үед хэрэглэх дүүжин шатны аюулгүй ажиллагааны дүрмийг удирдлага болгоно. 6. Өндөрт ажиллах болон багаж хэрэгсэлтэй аюулгүй ажиллах зааварчилгааг тогтмол өгж, аюулгүй байдлыг урьдчилан зохион байгуулна. <p>п. ...</p> <p><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Заслын ажлын аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. 3. Багаж, тоног төхөөрөмж, бараа материалтай болгоомжтой зааврын дагуу хэрэглэнэ. <p>п. ...</p>
С ₇	Барилгын гадна орчинд байрлах худаг, шуудуу, хонгил, бусад төрлийн нүх хонгилд ажил гүйцэтгэх	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Худаг, шуудуу, хонгил, бусад төрлийн нүх хонгилд орчимд ажилчны аюулгүй ажиллах нөхцөлийг хангуулна. 2. Барилгын талбайн орчим дахь нүхийг найдвартай таглаж осол гарахаас сэргийлнэ. 3. Барилгын гадна байгаа худаг, шуудуунд хязгаарлалт хийж, хамгаалалтын арга хэмжээ авна. 4. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгнө.

		<p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Худаг, шуудуу, хонгил, бусад төрлийн нүх хонгилд орчимд ажиллахад аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. <p>п. ...</p>
С₈	Барилгын угсармал төмөр бетон бүтээцийн ажил гүйцэтгэх	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэх төслийн дагуу угсармал төмөр бетон бүтээцийн ажлыг зохион байгуулна. 2. Ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллах зааварчилгааг ажилчдад өгнө. 3. Аюулгүй ажиллагааны шат, вандан, хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, хяналт тавина. 4. Угсармал төмөр бетон бүтээцийг өргөн тээвэрлэх үед ажилчны аюулгүй байдлыг хангасан байна. <p>п. ...</p> <p><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. 3. Өндөрт ажил гүйцэтгэх үед анхаарал болгоомжтой ажиллана. <p>п. ...</p>
С₉	Барилгын саравч, таганд өрөг өрөх, хашлага хавтан угсрах, хайс хийх	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэхэд шаардлагатай шат вандангийн аюулгүй ажиллагааны нөхцөлийн хангана. 2. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилчдад тогтмол өгч, хяналтыг тогтмол хийнэ. 3. Барилгын гадна талын саравч, тагтын хэсэгт ажил гүйцэтгэх үеийн хэвтээ босоо хамгаалалтыг найдвартай хийсэн байна. 4. Барилгын гадна талын зорчих хэсгийн аюулгүй байдлыг хангасан байх <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Өндөрт болон барилгын гадна талд ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. <p>п. ...</p>
С₁₀	Олон давхар барилгын ган	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын төрөл бүрийн бүтээцийг угсрах ТК урьдчилан боловсруулж мөрдөнө.

	болон төмөр бетон багана, дам нуруу, хучилт, олон алслалтай дам нуруу, үйлдвэр ийн барилгын төмөр бетон, ган татанга, дагалдах эдлэхүүн зэргийг угсрах	<ol style="list-style-type: none"> 2. Угсралтын ажлын шатыг норматив баримт бичгийн шаардлагын дагуу бэлтгэнэ. 3. Энэ ажлыг гүйцэтгэх туршлага ур чадвартай ажилчдыг сонгон авч ажлын багийг зөв бүрдүүлнэ. 4. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн хангана. <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. <p>п. ...</p>
С₁₁	Инженерийн шугам сүлжээний угсралтын ажлын технологийн картыг (ТК) боловсруулж, ажил гүйцэтгэх	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Инженерийн шугам сүлжээний ажлыг технологи, ажлын дэс дарааллын дагуу зохион байгуулна. 2. Ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилчдад тогтмол өгнө. 3. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангана. <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 2. Хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. <p>п. ...</p>
С₁₂	Барилгын шилэн фасад угсрах засварлах ажил гүйцэтгэх	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын шилэн фасад угсрах засварлах ажлыг мэргэжсэн багаар хийлгэнэ. 2. Тус ажлыг хийх технологийг тусгайлан боловсруулж аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангана. 3. Босоо, хэвтээ чиглэлд өндрийн хамгаалалтыг найдвартай хийнэ. 4. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангана. <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 3. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана. 4. Хамгаалах хэрэгсэлийг бүрэн хэрэглэнэ. <p>п. ...</p>
С₁₃	Барилгын талбай дахь тээвэрлэлтийг	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын талбайн зохион байгуулалтын зураглалын дагуу тээвэрлэлтийг зохион байгуулна.

	зөв зохион байгуулах	<p>2. Тээвэрлэлтийг норматив баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгүүлнэ.</p> <p>3. Болзошгүй аюулаас сэргийлэх арга хэмжээ авна.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримталж ажиллана.</p> <p>2. Тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний үед анхаарал болгоомжтой зорчиж, ажил гүйцэтгэнэ.</p> <p>п. ...</p>
C ₁₄	Барилгад ус орох, салхины хүчний үйлчлэлд өртөх зэрэг байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Барилгын дотор гадна талд байгалийн нөлөөнөөс гарч болох эрсдэлийг урьдчилан тооцоолж эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авсан байна.</p> <p>2. Байгалийн нөлөөллөөс өөрийгөө хамгаалах аргыг ажилчдад зааварчилж зөвлөсөн байна.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Болзошгүй аюул ослын үед аюулгүй зорчих, биеэ хамгаалах зааварчилгааг баримтална.</p> <p>п. ...</p>
C ₁₅	Баригдаж буй барилга байгууламжид галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Барилгын талбайд гал гарах нөхцөлийг бүрэн хаах арга хэмжээ авна.</p> <p>2. Болзошгүй аюулаас сэргийлэх багаж хэрэгслийг ажилд бэлэн байлгана.</p> <p>4. Галын аюулгүй байдлыг норматив баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлнэ.</p> <p>5. Галд шатамхай бодис, материалын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлын нөхцлийг хангуулна.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Галын аюул осол гарахад нөлөөлөх үйлдлийг хийхгүй байх үүрэгтэй.</p> <p>2. Галд шатамхай бодис, материалтай анхаарал болгоомжтой харьцаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ажил гүйцэтгэнэ.</p> <p>п. ...</p>
C ₁₆	Төрөл бүрийн дээврийн ажлыг технологийг урьдчилан боловсруулж	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Гал түлж тос хайлдаг хуучин технологийг хэрэглэхгүй байна.</p> <p>2. Төрөл бүрийн дээврийн ажлыг гүйцэтгэх технологийн картыг боловсруулж, аюулгүй ажиллагааг хангуулна.</p> <p>3. Олон улсын стандартын дагуу технологийг</p>

	ажил гүйцэтгэх	<p>боловсруулж, аюулгүй ажиллагааны зааварчилгааны дагуу ажил гүйцэтгүүлнэ.</p> <p>4. Төрөл бүрийн дээврийг шинээр хийх, засварлах ажлыг гүйцэтгэх үед гадна талын хамгаалалтыг бүрэн хийсэн байна.</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Дээврийн материалыг хуулахдаа барилгын гадна тал руу татаж хуулахыг хориглоно.</p> <p>2. Дээврийн парпет ханан дээр юм хураах, сандайлж суухыг хориглоно.</p> <p>3. Дээвэрт байгаа нүхэнд унахаас сэргийлнэ.</p> <p>4. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.</p> <p>п. ...</p>
С ₁₇	Барилгын ажил гүйцэтгэх үед гуравдагч этгээдэд аюул учрахаас сэргийлэх арга хэмжээ авах	<p><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Барилгын талбайн аюулгүй хүрээг урьдчилан тогтоож, хүрээний дотор ажил гүйцэтгэх технологийг боловсруулж мөрдлөг болгоно.</p> <p>2. Барилгын талбайн эргэн тойрны гадна орчин, зорчих хэсгийн аюулгүй байдлын нөхцлийг хангуулна.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Барилгын дээрээс гадагш бараа материал унагаахыг хориглоно.</p> <p>п. ...</p>
С ₁₈	Газар шорооны ажил гүйцэтгэх	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Тухайн барилга байгууламжийн баталгаажуулсан зураг төсөлд үндэслэн ажил гүйцэтгэх төслийг боловсруулна.</p> <p>2. Ажил гүйцэтгэх төслийн дагуу барилгын ажлын талбай зохион байгуулалтын зурагт хөдөлмөрийн аюулгүй байдлаас хамгаалсан арга хэмжээг тусгана.</p> <p>3. Газар шорооны ажил гүйцэтгэх үед үүсэх аюул осол, эрсдэлийн үнэлгээг хийж, авах арга хэмжээг ажил гүйцэтгэх төсөлтэй уялдуулан зохион байгуулна.</p> <p>4. Аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж, ажилчдад таницуулж, хамгаалах хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжөөр хангана.</p> <p>5. Хөрсний нуралт, гулсалт болон бусад зүйлээс учирч болзошгүй хаалт, хамгаалалт, бэхэлгээг тооцооны үндсэн дээр хийсэн байна.</p> <p>6. Үзэгдэх орчин хязгаарлагдмал болон онцгой нөхцөл байдлын улмаас үүсэх аюулыг нөхцөл байдлыг байнгын хянана.</p> <p>7. Ажилчдад газар шорооны ажил гүйцэтгэх машин механизм, багаж тоног төхөөрөмжийн</p>

		<p>хөдөлгөөнөөс сэргийлэх заавар өгнө.</p> <p>8. Ажилд хэрэглэх багаж тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана.</p> <p>9. Барилга байгууламжийн суурийн эргэн тойрон дахь хөдөлгөөнийг зохион байгуулж, гуравдагч этгээдийг аюулд өртөхөөс сэргийлэх арга хэмжээ авна.</p> <p>10. Ажил гүйцэтгэх үед хөдөлмөрийн аюулгүй байдлын хэрэгжилтийг байнга хянаж, заавар өгөх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.</p> <p>п. ...</p> <p style="text-align: center;"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Газар шорооны ажлын аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөнө.</p> <p>2. Хамгаалах хувцас, багаж хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.</p> <p>3. Газар шорооны ажил гүйцэтгэх машин механизм, тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс сэргийлж ажиллана.</p> <p>4. Амралт, завсарлагааны цагаар суурийн хэсэгт зорчих, илүү болгоомжгүй хөдөлгөөн хийхийг хориглоно.</p> <p>п. ...</p>
C₁₉	Барилгад нүүрс, кокс, хортой утаа гаргадаг зүйлийг түлэх, шатаах ажиллагааг бүрэн хориглох	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Ямар ч нөхцөлд барилгын дотор тал, гадна суваг шуудуунд ил гал түлэхийг бүрмөсөн хориглоно.</p> <p>п. ...</p>
C₂₀	Барилгын орц гарцыг тухайн нөхцөлд тохируулж гаргах	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Баригдаж буй барилгын орц гарцын аюулгүй байдлыг бүрэн хангах нөхцлийг бүрдүүлнэ.</p> <p>2. Орж, гарах хэсэгт түр зам, гүүр, хаалт, хамгаалалт хийнэ.</p> <p>п. ...</p>
C₂₁	Барилгын ажлыг удирдах, ажил гүйцэтгүүлэх, мэргэжлийн ажилчдыг зөв хуваарилах	<p style="text-align: center;"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Тухайн ажлыг гүйцэтгэх чадвартай, мэргэжлийн шаардлага хангасан ажилчинг зөв хуваарилна.</p> <p>2. Мэргэжлийн бус хүнээр барилгын ажлыг удирдуулахыг хориглоно.</p> <p>п. ...</p>

С ₂₂	Ажлын туршлагагүй, анхлан ажил эрхэлж буй ажилчдад сургалт, зааварчилгаа өгөх, ажилд зөв хуваарилах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Ажлын туршлагагүй, анхлан ажил эрхэлж буй ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, дадлагажуулах, эзэмшүүлэх ажлыг тогтмол зохион байгуулна. 2. Ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллах зааварчилгаа зөвлөмжийг мөрдүүлнэ. 3. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангана. <p>п. ...</p> <p align="center"><u>Ажилчны үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг чанд мөрдөнө. <p>п. ...</p>
С ₂₃	Хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн эмэгтэйчүүд болон насанд хүрээгүй хүүхдээр ажил гүйцэтгүүлэх	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй мөн жирэмсэн эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүүхдээр ажил гүйцэтгүүлэхэд хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох норматив баримт бичгийн шаардлагыг мөрдөнө. 2. Норматив баримт бичгийн дагуу ажил хуваарилж, аюулгүй ажиллах нөхцөлийг нь хангуулна. 3. Ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллах зааварчилгаа зөвлөмжийг мөрдүүлнэ. 4. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангана. <p>п. ...</p>
С ₂₄	Барилгын талбайн болон ажлын байрны гэрэлтүүлгийг норматив баримт бичгийн дагуу хангах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгын талбай болон ажлын байрны гэрэлтүүлгийг ажил гүйцэтгэх нөхцөлийн дагуу бүрдүүлнэ. <p>п. ...</p>
С ₂₅	Шатамхай материалын шаталтын хортой утаанд хордох аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Барилгад хэрэглэдэг хөөсөнцөр, лампер зэрэг хортой хий ялгаруулдаг материалыг шатаах үйлдэлийг хориглоно. <p>п. ...</p>

С ₂₆	Инженер техникийн ажилтан болон ажилчдыг аливаа болзошгүй эрсдэлээс өөрийгөө хамгаалах арга барилд сургаж дадлагажуулах	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Инженер техникийн ажилчдад аливаа эрсдэлээс өөрийгөө хамгаалах аргад байнга суралцуулж байна.</p> <p>п. ...</p>
С ₂₇	Хүйтний улиралд барилгын ажил гүйцэтгэх	<p align="center"><u>Байгууллагын үүрэг</u></p> <p>1. Хүйтний улиралд барилгын ажлыг аюулгүй гүйцэтгэх арга технологийг боловсруулж, мөрдүүлнэ.</p> <p>2. Хүйтний улиралд ажиллах ажилчдын аюулгүй ажиллагаа болон ажиллах нөхцлийг бүрэн хангана.</p> <p>3. Ажил гүйцэтгэх болон аюулгүй ажиллах зааварчилгаа зөвлөмжийг мөрдүүлнэ.</p> <p>4. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангана.</p> <p>п. ...</p> <p align="center"><u>Ажилчны үүрэг</u></p> <p>1. Аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдөж ажиллана.</p> <p>2. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг бүрэн хэрэглэнэ.</p> <p>п. ...</p>
.....		
С _n		

ТАЙЛБАР:

С БҮЛГИЙН ЭРСДЛЭЭС СЭРГИЙЛЭХ АЖЛИЙГ ГҮЙЦЭТГЭХДЭЭ ДАРААХ НОРМЫГ МӨРДӨНӨ.

1. БНБД 12-03-04 Барилгын үйлдвэрлэлд дараж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм 1 хэсэг. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2. БНБД 12-03-06 Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм 2 хэсэг. Тэхникийн аюулгүй ажиллагааны дүрэм
3. БД 12-105-07 Барилгын материалын үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм
4. БД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн дүрэм
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгаа гарын авлага
6. УББ 12-204-01 Барилгын талбайн даамлын үлгэрчилсэн дүрэм
7. БНБД 21-01-02 Барилга байгууламжийн галын аюулгүй байдал
8. MNS 6228-1 : 2010 барилгын ажилчдын мэргэжлийн стандарт. 1-р хэсэг: ерөнхий шаардлага
9. MNS6228-3 :2011 Барилгын механизмын ажилчдын мэргэжлийн стандарт . 3-р хэсэг: ерөнхий шаардлага

7. Ажлын байрны зааварчлага өгөх аргачилсан зөвлөмж

7.1. ХАБЭА-ын ажлыг хэрэгжүүлэх зааварчлага өгөх баримт бичгийн жишээ

Хавсралт 3

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Зааварчилгаа өгсөн хүний /Овог..... Нэр....., Гарын үсэг/
.....

Албан тушаал..... Мэргэжил.....

201.....он Сар
Өдөр Гариг.....

MNS4969:2000

Давтан зааварчилгын хэлбэр

а. Ээлжит б. Ээлжит бус в. Ажлын байран дахь өдөр
тутмын

Дугаар	ХАБЭА-н зааварчилгааны ерөнхий утга, код	№	Овог нэр	Зааварчилгаа авсан хүний гарын үсэг
1	Газар шорооны ажил гүйцэтгэх-С ₁	1	Б.Эрдэнэбаатар	
		2	Л.Алтанбагана	
		3	А.Алтансүх	
		4	Б.Балжинням	
		5	Н.Батцэнгэл	
		6	Б.Батцэцэг	
		7	Б.Баяраа	
		8	А.Даваадалай	
		9	Ч.Даянбаатар	

	10	П.Жамсранжав	
	11	Г.Зоригтбаатар	
	12	Б.Мөнхцэцэг	
	13	П.Мөнх –эрдэнэ	
	14	О.Мягмардорж	
	15	Г.Натар	
	16	Ц.Отгонбаатар	
	17	Д.Сүх баатар	
	18	Б.Хосбат	
	19	Ч.Цогтсайхан	
	20	Ц.Энэбиш	
	21	Б.Батчулуун	
	22	Л.Ядамсүрэн	
	23	Д.Наранцэцэг	
	24	Л.Ууганбаяр	
	25	Ц.Мөнхгэрэл	

7.2. ХАБЭА-н ажлыг хэрэгжүүлэх талаар харилцан тохиролцож хариуцлагын тогтолцоог баталгаажуулсан баримт бичигт дараах зүйлийг заавал тусгана.

Үүнд:

- Хэв хашмалын тулгуур төмөр, модыг буруу үйлдлээр цохиж авахыг бүрэн хориглоно.
 - Барилга дээрээс хог болон аливаа зүйлийг доош хаяхыг бүрэн хориглоно.
 - Аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгсэлгүйгээр ажил гүйцэтгэхийг хориглоно.
- Дээрх буруу аюултай үйлдлийг ямарч тохиолдолд гаргахгүй байхыг онцгой анхаарч, холбогдох зааварчилгааг тогтмол өгч, үүдэн гарах ослыг бүр мөсөн арилгахыг эрмэлзэх хэрэгтэй. Үүнийг дагаж мөрдөхийг байгууллагын дотоод журам, дүрэмд заавал оруулж, холбогдох хариуцлагыг тогтоож, хүлээлгэх асуудлыг тодорхой тусгасан байна. Энэ буруу үйлдлийг гаргасан этгээд нь хамт олны болон хуулийн өмнө хариуцлага хүлээнэ гэдгийг байнга сануулж, зааварчилсан байна.

8.Барилгын ХАБЭА-н ажлын найдвартай, шуурхай байдал

8.1.Барилгын ХАБЭА-н бүхий л ажилд орчин үеийн мэдээлэл холбооны хэрэгслийг заавал хэрэглэж ХАБЭА-н ажлыг камерын бичлэг, видео бичлэг, дуу хураагуур, фото зураг, компьютерын сүлжээгээр мэдээллийн сангаар баталгаажуулах, ХАБЭА-н зааварчилгаа, сургалтыг кино, чанга яригч ашиглаж хийх, аж ахуйн нэгжүүд барилга, үйлдвэрийн цехийн ХАБЭА-н ажлыг хянаж удирдах дотоодын мэдээллийн шуурхай сүлжээг буй болгож энэ ажлыг техникийн дэвшлээр удирдах нь барилга угсралтын аж ахуйн нэгжийн удирдлагын гол үүрэг байна

ТӨГСӨВ.

